

Ирээдүйг хамтдаа бүтээх нь: Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний газрын стратеги төлөвлөлт

Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний газар гэж юу вэ?

Арлингтон мужийн аюулгүй байдлын сүлжээний системийн тулгуур багана болох Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний Газар (НҮГ) нь 800 гаруй ажилтантай нэгдсэн байгууллага бөгөөд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ, зан үйлийн эрүүл мэнд, хүүхэд, гэр бүлийн үйлчилгээ, эдийн засгийн хараат бус байдал, нийгмийн эрүүл мэнд гэсэн таван үндсэн чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг. Үүнээс гадна НҮХ нь 50 орчим ашгийн бус байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, олон нийтийн хэрэгцээг бүрэн хангаж ажилладаг. НҮХ нь Арлингтон мужийн хамгийн том газар бөгөөд жилд 58,000 гаруй хүнд үйлчилдэг бөгөөд Medicaid, SNAP, орон сууцны татаас, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ, сургуулийн эмнэлэг, насанд хүрэгчдийн хамгааллын үйлчилгээ, хүүхдийн халамж, олон нийтийн үйлчилгээний зөвлөл (ОНҮЗ) зэрэг хөтөлбөрүүдэд сэтгэцийн эрүүл мэнд, бодисын хэрэглээ, хөгжлийн дэмжлэг шаардлагатай хүмүүст зориулагдсан.

Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний газар нь эрүүл, аюулгүй, эдийн засгийн баталгаатай, нийгэмд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлээс ангид шударга, эрх тэгш нийгмийг бий болгох алсын хараатай ажилладаг. Байгууллагын эрхэм зорилго нь хар арьстан, уугуул иргэд, өнгөт арьстнуудтай эв санааны нэгдэлтэй байж, нийгмийн гишүүн бүр эрүүл, аюулгүй, эдийн засгийн хувьд баталгаатай байх шаардлагатай нөөц, боломжийг тэгш хүртээмжтэй болгох явдал юм.

Нийгмийн Үйлчилгээний стратеги төлөвлөгөө гэж юу вэ?

Нийгмийн Үйлчилгээний стратеги төлөвлөгөө нь нийгмийн үйлчилгээний газрын эрхэм зорилго, зорилт, нийгэмд зайлшгүй шаардлагатай үйлчилгээг хүргэх стратегийг нарийвчлан тодорхойлсон цогц баримт бичиг болно. Эрүүл мэнд, нийгмийн сайн сайхан байдал, эдийн засгийн тогтвортой байдалтай холбоотой нарийн төвөгтэй, байнга өөрчлөгдөж буй хэрэгцээг шийдвэрлэх замын зураглал болж, оршин суугчдыг дэмжихэд харьяа байгууллага нь хариу үйлдэл үзүүлэх, үр дүнтэй ажиллахад тусалдаг.

Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний газар яагаад стратеги төлөвлөгөө гаргах шаардлагатай вэ?

Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний газар нь газрын алсын хараа, эрхэм зорилгыг биелүүлэх зорилгоор стратеги төлөвлөгөө боловсруулдаг. Энэхүү төлөвлөгөө нь тэгш бус байдлын асуудлыг шийдвэрлэхийн тулд тодорхой тэргүүлэх чиглэл, холбогдох арга хэмжээг тогтоох замаар шударга, тэгш нийгмийг бий болгох хүчин чармайлтыг удирдан чиглүүлдэг. Бодлого, үйлчилгээг хүртээмжтэй, соёлын мэдрэмжтэй, хүн бүрд хүртээмжтэй байлгах замаар стратеги төлөвлөгөө нь газрын эрхэм зорилгыг олон нийтийн хэрэгцээг хангах, эрүүл мэнд, аюулгүй байдал, эдийн засгийн баталгаат байдалд тулгардаг тогтолцооны саад бэрхшээлийг арилгахад чиглэсэн тодорхой санаачилгуудтай уялдуулахад тусалдаг. Мөн байгууллагад

хэмжигдэхүйц зорилго тавьж, оршин суугч бүр арьс өнгөний тэгш бус байдалтай тулгарахгүйгээр хөгжих боломжтой хамт олныг бий болгоход чиглэсэн ахиц дэвшлийг хянах замаар эгэх хариуцлагыг дэмжихэд тусалдаг.

Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний стратеги төлөвлөгөөнд ямар үр дүнг тусгадаг вэ?

Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний газар стратегийн төлөвлөгөө нь бие махбодын болон зан үйлийн эрүүл мэнд, Орон сууцны тогтвортой байдал, Аюулгүй байдал, Урьдчилан сэргийлэлт, Эрүүл оршихуй, Эдийн засгийн баталгаат байдал, Хүртээмжтэй олон нийтийн холбоо, Зохион байгуулалтын чадавхын үр дүнд гол төвлөрдөг. Дэлгэрэнгүй мэдээллийг үзэх (<https://arlingtonva.us/Government/Departments/DHS/Strategic-Plan>).

Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний газар яагаад стратегийн хэрэгцээний судалгаа хийдэг вэ?

Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний газарт Арлингтон мужийн оршин суугчдын хэрэгцээг ойлгох, тэдгээрийг шийдвэрлэх Нийгмийн Үйлчилгээний стратеги төлөвлөгөө боловсруулахад олон нийтийн оролцоо шаардлагатай байна.

Судалгааг бөглөхөд хэр хугацаа шаардагдах вэ?

Судалгааг хийж дуусахад 10-15 минут болно.

Судалгааг хаанаас харах вэ?

Та эндээс судалгаа харж болно <https://www.research.net/r/ArlingtonCS> . Мөн Нийгмийн үйлчилгээний яам, орон нутгийн олон байршлуудад судалгааг мөн авч буй.

Судалгааг хэзээ хийх вэ?

Судалгаа нь 2024 оны 10-р сарын 28-наас 12-р сарын 2 хүртэл нээлттэй байна.

Судалгаанд миний мэдээлэл нууц байх уу?

Тийм, шударга, илэн далангүй санал хүсэлтийг дэмжих зорилгоор оролцогчдын мэдээллийг нууцална. Таны хариуцлыг нууцална.

Судалгааг олон хэл дээр бөглөх боломжтой юу?

Тийм ээ, судалгааг англи хэл болон зургаан өөр хэл дээр бөглөх боломжтой: Араб хэл (العربي), Амхарик (አማርኛ), Бенгал (বাংলা), Монгол (Монгол), Орос (орос), Испани (Español).

Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний газар судалгааны үр дүнг юунд ашиглах вэ?

Судалгааны үр дүнг Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний газраас үзүүлж буй олон нийтийн үйлчилгээг ойлгох, сайжруулах, стратеги төлөвлөлтийг олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх зорилгоор ашиглана.

Судалгааны үр дүнг цаашид олон нийтийн хүртээл болгох уу?

Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний газрын стратеги төлөвлөгөө болон холбогдох өгөгдлүүдийн талаарх мэдээллийг дараах холбоосноос авч болно
<https://arlingtonva.us/Government/Departments/DHS/Strategic-Plan>

Ямар нэгэн фокус бүлэг байх уу?

Тийм, Нийгмийн үйлчилгээний хөтөлбөр, үйлчилгээг ашигласан цөөн тооны хүмүүсийг фокус бүлэгт оролцохыг урьж байна. Хэрэв та сонирхож байгаа бол энд дарна уу: <https://forms.gle/UHysoD8RTYEcougBA>

Нэмэлт мэдээлэл, тусламж хэрэгтэй бол хаана хандах вэ?

Манай тусламжийн багтай холбоо барин team@carrington-consulting.com дэлгэрэнгүй мэдээлэл, тусламж авна уу.

Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний газрын стратеги төлөвлөгөөний талаар илүү их мэдээлэл авч, энэхүү санаачилгын явцын талаар мэдээлэл авах боломжтой юу?

Арлингтон мужийн Нийгмийн Үйлчилгээний газрын стратеги төлөвлөгөө болон холбогдох мэдээллийг дараах холбоосноос авах боломжтой
<https://arlingtonva.us/Government/Departments/DHS/Strategic-Plan>